



БНМАУ
УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ЗАХИРАМЖ

1993 оны 4...
сарын 30 өдөр

Дугаар А. 96.

Улаанбаатар
хот

Гэрлэх ёслолын ордоны
тухай

1. Гэрлэх ёслолын ордонг одоогийн материаллаг баазад нь тулгуурлан "Гэрлэх ёслолын ордон" /УҮГ/ болгон өөртөө үйлчилгээ худалдаа зохион байгуулах эрхтэйгээр байгуулсугай.

2. Гэрлэх ёслолын ордоны дүрмийг хавсралт ёсоор баталсугай.

3. Гэрлэх ёслолын ордоны даргаар Х.Ожунчимэгийг томилсугай.

4. Энэ тэгтоол гарсантай холбогдуулан Улаанбаатар хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны 1991 оны 360 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ
ДАРГА

Ц.Баасанжав

Ц.БААСАНЖАВ



Нийслэлийн Засаг даргын 1993
онд 4 дүгээр сарын 29-ны өд-
рийн А-96 тоот захирамжийн
хавсралт

ГЭРЛЭХ ЁСЛОЛЫН ОРДОНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Гэрлэх ёслолын ордон нь Нийслэлийн Засаг даргын харьяа байгууллага мөн.

2. Гэрлэх ёслолын ордон нь Монгол улсын Гэр бүлийн хууль, түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан хууль эрхийн актыг үндэслэн гэр бүл болох залуу хосуудын хуримын ёслолын үйл ажиллагааг хүндэтгэлтэйгээр зохион явуулах гол үйлчилгээг эрхлэн явуулна.

3. Тус ордон нь өөрийн үйл ажиллагааг бие даасан байдлаар явуулах бөгөөд үйлчилгээ, аж ахуйн үйл ажиллагаагаа аж ахуйн тооцооны үндсэн дээр өөрөө санхүүжүүлэх зарчим, өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэн ажиллана.

4. Тус ордон нь улсын өмчийн тодорхой хэсгийг эзэмшиж, Улсын үйлдвэрийн газарт хамрагдан үйл ажиллагааны тодорхой эрх эдлэн, үүрэг хүлээж биеэ даасан харилцах данс, тэнцэтгэлтэй хуулийн этгээд болно.

5. Биеэ даасан хуулийн этгээд болох тул албан бичгийн болон албан тушаалын хэвлэмэл хуудас, тамга тэмдэг хэрэглэнэ.

Хоёр. Гэрлэх ёслолын ордонь үүрэг, эрх

1. Гэр бүл болж буй залуусын хуримын ёслолын үйл ажиллагааг зохион байгуулна.

2. Ёслол хийх залууст худалдаагаар үйлчилнэ.

3. Үйлчлүүлэгчдийг ямагт хүндэтгэн тэдэнд хөнгөн шуурхай, соёлтой үйлчилнэ.

4. Залуу гэр бүлийн эрүүл ахуй, аж төрөх ёс, эр эмийн ёс зүйн талаар төрөл бүрийн сургалт зохион байгуулна.

5. Төрөл бүрийн уулзалт, нэмэгдэл үйлчилгээ явуулж, барааны фонд болон орлогын эх үүсвэрээ нэмэгдүүлэн ажиллана.

6. Үйлчилгээ явуулахтай холбогдон үйлдвэр, худалдааны болон бусад пүүс, компани, ХЭАА-тай аж ахуйн гэрээтэй ажиллаж гэрээний хээ үүргийг чанд сахина.

2.

7.Тус ордноос явуулах үйлчилгээний үнэ тарифыг өөрөө тогтоож нийслэлийн үнийн комиссоор хянуулан бүртгүүлж мөрдөнө.

8.Тамгын газартай тохиролцож гадаадын пүүс, компани зэрэг байгууллагатай хамтран ажиллах гэрээ хэлцэл хийх, харилцаа тогтоох, ажилтан солилцох эрхтэй.

9.Тамгын газартай тохиролцож тээврийн хэрэгсэл болон тоног төхөөрөмж эд хогшил худалдан авах захиран зарцуулах эрхтэй.

10.Өөрийн үйл ажиллагааны үр дүнгээс зардлаа нөхөж олсон үр ашгийг ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, байгууллагаа хөгжүүлэхэд зарцуулж байхын зэрэгцээ төсвийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлнэ.

Гурав.Удирдлага

1.Гэрлэх ёслолын ордоны даргыг Нийслэлийн Засаг дарга томилно.

2.Ордоны дарга ажилтнуудыг хөдөлмөрийн хуулийн дагуу ажилд авах, ажлаас чөлөөлөх, амралт, чөлөө олгох шагнаж урамшуулах асуудлыг хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр шийдвэрлэж ажиллана.

3.Ордоны дарга нь байгууллагаа төлөөлж бусад байгууллага, газартай харилцах, гэрээ байгуулах, эд хөрөнгийг хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах итгэмжлэн олгох эрхтэй.

4.Ордоны дарга ордоны дотоод журмыг хамт олноор хэлэлцүүлэн гаргаж, түүний мөрдөлтөнд хяналт тавьж ажиллана.